

Дэлхийн онцог булан бүрд олон улсын “Энхийг сахиулагчдын одор”-ийг жил бүрийн тавдугаар сарын 29-нд тэмдэглэн онгорvvлдэг. НҮБ-ын гишvvн орнууд дэлхийн энхийн вйл хэрэгт хувь нэмэр оруулж буй энхийг сахиулагчдадаа хvндэтгэл vзvvлсээр ирсэн энэхvv одрийг Монгол Улс ч оорийн оронд зохион байгуулан тэмдэглэж байна. 2011 онд Монгол Улсад тvvхт их ойнууд тохиож байгаатай холбогдуулан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн торийн захиргааны тов байгууллага vвсэн байгуулагдсаны 100 жил, олон улсын “Энхийг сахиулагчдын одор”-ийг тэмдэглэн онгорvvлэх арга хэмжээний хvрээнд БХЯ, ЗХЖШ, БХИС, БХЭШХ хамтран “Монгол Улсын цэргийн баг Сьерра Леон, Чадын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршлага, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2011 оны 05 дугаар сарын 27-ны одор зохион байгуулж явууллаа.

Хуралдаанд Батлан хамгаалахын дэд сайд С.Баасанхvv, БХЯ-ны Торийн нарийн бичгийн дарга, хошууч генерал М.Борбаатар, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав, ЗХЖШ-ын дэд дарга, хошууч генерал Б.Баярмагнай, Батлан хамгаалахын сайдын зовлох Ц.Ганболд, Д.Ганзориг (Үндэсний аюулгvй байдлын зовлол), болон Гадаад Харилцааны Яам, vндэсний аюулгvй байдлыг хангах чиг vврэг бvхий байгууллагуудын толоолол оролцов.

Хуралдааныг Батлан хамгаалахын сайдыг толоолон Батлан Хамгаалахын сайдын зовлох Ц.Ганболд vг хэлж нээв.

Хурлын ажиллагаанд:

Монгол Улс Энхийг сахиулах ажиллагааны талаар баримталж буй бодлого, вйл ажиллагаа, хандлага

Монгол Улсын гадаад бодлого ба энхийг сахиулах ажиллагаа

Монгол Улсын Зэвсэгт хvчин Энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршлага, сургамж (сургалт, бэлтгэл)

Энхийг сахиулах ажиллагаа ба олон нийтийн санал бодол (судалгааны vр дvн)

НҮБ-ын UNMIL энхийг сахиулах ажиллагаанд vврэг гvйцэтгэсэн туршлага, сургамж, дvгнэлт (Сьерра Леон)

НҮБ-ын MINURCAT энхийг сахиулах ажиллагаанд vврэг гvйцэтгэсэн туршлага, сургамж, дvгнэлт (Чад) илтгэлvvдийг хэлэлцvvллээ.

Хуралд оролцогсод болон эрдэмтэн, судлаач зочид санал бодлоо илэрхийлэн vг хэлж, санал шvvмжлэл орнvvлсэн ба тэд хурлын ажиллагааг амжилттай, ач холбогдол ондортэй зохион байгуулагдаж буйг тэмдэглэж байлаа.

Хурлын ажиллагаанд ҮАБЗ, БХЯ, ГХЯ, ТЕГ, ЗХЖШ, БХИС, БХЭШХ, ССХ, МУИС, ХХЕГ, ШШГЕГ, ЦЕГ зэрэг олон байгууллагуудын толоолол хуралд оролцсон явдал нь хурлын цар хvрээ, ач холбогдлыг илтгэж энэ сэдэв, чиглэлийг илvv сонирхож байгааг харуулж байв.

Энэхvv эрдэм шинжилгээний хурлыг хааж Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалах яамны шинжлэх ухаан технологийн зовлолийн дарга С.Баасанхvv vг хэлж тодорхой vврэг чиглэл огсон.